



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/639

Улаанбаатар хот

Г Магадлан итгэмжлэл олгох тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаа тасарч сунгагдаж буй эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэл эхлэх хугацааг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн тооцсугай.

3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 26 дугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141223082

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12
дугаар сарын 28 - ны өдрийн 4/639
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Хан-уул дүүрэг, Туул тосгоны эрүүл мэндийн төв	463/2022	1 жил	2022.12.28	2023.12.28
2.	Нийслэлийн Энэрэл эмнэлэг	464/2022	4 жил	2022.12.31	2026.12.31
3.	ШШГЕГ-ын харъяа цагдан хорих 461-р ангийн нэгдсэн эмнэлэг	465/2022	3 жил	2023.01.01	2026.01.01
4.	ШШГЕГ-ын харъяа хорих 401 дүгээр ангийн нэгдсэн эмнэлэг	466/2022	2 жил	2023.01.12	2025.01.12
5.	Налайх дүүргийн эрүүл мэндийн төв	467/2022	3 жил	2023.01.02	2026.01.02
6.	Уламжлалт анагаах ухааны элэг судлалын төв	468/2022	2 жил	2023.01.02	2025.01.02
7.	Тунгалаг онги ХХК-ийн Ээлтэй оточ сувилал	469/2022	3 жил	2023.01.01	2026.01.01
8.	Дундговь аймаг, Дэрэн сумын эрүүл мэндийн төв	470/2022	2 жил	2023.01.02	2025.01.02
9.	Дундговь аймаг, Эрдэнэдалай сумын эрүүл мэндийн төв	471/2022	3 жил	2023.01.02	2026.01.02
10.	Хэнтий аймаг, Бор өндөр сум, Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	472/2022	3 жил	2023.01.01	2026.01.01

оо0оо